



**“УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар Б/56

Улаанбаатар хот

**Р.Сийлэгмааг ажлаас чөлөөлж,
нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Тус театрын Тайзны машинист Ринчиндоржийн Сийлэгмааг 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
- 2.Монгол улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-д заасны дагуу Р.Сийлэгмаад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тооцон олгохыг Нягтлан бодогч (С.Эрдэнэцэцэг)-д зөвшөөрсүгэй.
- 3.Р.Сийлэгмаа нь өндөр насны тэтгэвэр тогтоолгож, ажлаас чөлөөлөгдөж байгаатай холбогдуулан санхүүгийн болон эд аж ахуйн холбогдох тооцоог хийж, ажил хүлээлцэх ажлыг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулж ажиллахыг Нягтлан бодогч (С.Эрдэнэцэцэг), Нярав (Д.Дэлхийцэцэг) нарт даалгасугай.
- 4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны ахлах мэргэжилтэн (Б.Түмэндэлгэр), Хүний нөөцийн менежер (Л.Одгэрэл) нарт үүрэг болгосугай.

ДАРГА




Ю.ГЭРЭЛБААТАР